

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ СУРГУУЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б. Хашчулуу
Докторант

Нийслэлийн 97 дугаар сургууль

hashchuluub@gmail.com

Хураангуй: 1990-ээд оны дунд үеэс эхэлсэн тогтолцооны шинэчлэлийн хүрээнд хандивлагч орнуудын дэмжлэгээр нийгмийн амьдралын бүхий л салбарт неолиберал бодлого хэрэгжиж эхэлсэн билээ. Энэхүү өгүүлэлд боловсролын харилцаан дахь неолиберал бодлогын шинэ агент - олон нийтийн оролцоот сургуулийн өнөөгийн байдлыг авч үзлээ. Судалгаанд олон нийтийн оролцоот сургуулийн нэгэн хэлбэр Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны загвар, хамрах хүрээ, олон нийтийн ойлголт, хандлагыг орон нутгийн түвшинд тандалт судалгаа хийж үр дүнг танилцуулж байна.

Түлхүүр үгс: Эцэг эхийн зөвлөл, оролцоо, сургуулийн үйл ажиллагаа, эгэх хариуцлага

УДИРТГАЛ

Тогтвортой хөгжилд суурилсан XXI зууны боловсролын үзэл баримтлал нь сургуулиар дамжуулан эцэг эх, олон нийтийн тасралтгүй хөгжлийг дэмжих, сургууль өөрийн үйл ажиллагаанд эцэг эх олон нийтийн бүтээлч оролцоог нэмэгдүүлж нээлттэй, ил тод байх хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Энэхүү ил тод, нээлттэй байдлын зарчим нь төсвийн хязгаарлагдмал, явцуу зарцуулалтыг нийтэд мэдээлэх гэхээсээ эцэг эх, олон нийтийн оролцоонд тулгуурлан асуудлаа тодорхойлох, шийдлийг санал болгох, үр дүнг мэдээлэх, шинэчлэн сайжруулахад чиглэсэн сургуулийн менежментийн нэгэн загвар болж байна.

Олон нийтийн оролцоот сургууль. Нийтийн үйл хэрэгт

иргэний оролцооны тухай үзэл санаа 50-иад оноос түгэн дэлгэрсэн бөгөөд хөгжлийн үр шимээс бүгд тэгш хүртэж, нийгмийн гишүүн нэг бүр хөгжлийн үйл явцад идэвхтэй хувь нэмэр оруулж, нөлөөлөх боломж бол оролцооны тухай ерөнхий ойлголт (UN document, 1981, р5) бөгөөд сургууль дахь оролцоог эцэг эхийн нийгмийн гарал, боловсролын байдлаас үл шалтгаалан амжилттай суралцахуй хийгээд багшлахуйн чанарт нөлөөлөх хамгийн гол зүйл (Phillip F.A Matshe, Victor J.Pitsoe, 2013, р645) болохыг судлаачид онцолж байна.

Олон нийтийн сургууль - оролцоонд тулгуурласан хамтын ажиллагааг онцолж, эцэг эх, багш олон нийтийн төлөөллийн байгууллагаар дамжуулан идэвхтэй оролцоог шаарддаг, сургууль бол

тогтолцооны зөвхөн нэг хэсэг болохыг хүлээн зөвшөөрч, хүүхэд, өсвөр залуус, насанд хүрэгсдийн төлөө нийгмийн хөгжлийн төв байх ёстой гэж үздэг (Russel, Robert, 1956, p426).

Сургуулийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог 1970-аад оноос онцлох болж, засгийн газар боловсролын үйлчилгээг ганцаар хэрэгжүүлэгч бус, олон нийт - суурь боловсролын үр нөлөө, уялдааг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй оролцох тухай дурьдаж, 1980-аад оноос олон нийт зөвхөн үйлчилгээг хүлээн авагч бус *хөгжүүлэгч, суралцагч олон нийт - оролцогч* болохыг хүлээн зөвшөөрч эхэлсэн юм.

1990-ээд оноос неолиберал эдийн засгийн онол болон либерал ардчиллын онолын нөлөөгөөр “бодлогын шинэ агент” гэж нэрлэгдсэн иргэний нийгмийн олон байгууллагууд эдийн засгийн хувьд амжилтад хүрч байсан нь донор орнуудын зүгээс өөрийн тусламжийн зорилтыг хүнд суртал авлигад автсан засгийн газарт бус, төрийн бус байгууллага болон иргэний нийгмийн байгууллагуудад чиглүүлж чадваржуулж эхэлсэн (Mikiko Nishimura, 2017) түүхтэй юм. Олон нийтийн оролцооны энэхүү үүргийг боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах “хариуцлагын механизм”-ын хүрээнд урт болон богино эгэх хариуцлагын тогтолцоо болохыг Дэлхийн банкны зөвлөмжид тулгуурлан Микико

Нишимура (2017) тодорхойлсон байна.

Богино эгэх хариуцлагын хүрээ нь *эцэг эх - үйлчлүүлэгчийн оролцоог* сургуулийн боловсролын үйлчилгээний чанарын тайлбар авч буй байдал, дэвшүүлсэн санал санаачилгыг сургууль үйл ажиллагаандаа тусгаж буй эргэх холбоогоор, сургуулийн зүгээс эцэг эхийн төлөөллийг оролцуулсан сургуулийн зөвлөл, хороо байгуулж сургалтын чанарыг сайжруулах, сургуулийн төлөвлөгөөг хэлэлцэхэд оролцуулсан - *олон нийтийн оролцоот* байдлаар хэмждэг. Иймээс олон нийт - эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд богино эгэх хариуцлагын хүрээг оновчтой тодорхойлж анхаарал хандуулах нь зүйн хэрэг юм.

Олон нийт-эцэг эхийн оролцооны хэлбэрийг төсвийн хуваарилалт зарцуулалт, хүний нөөцийн томилгоо, сурган хүмүүжүүлэх болон боловсролын агуулга бүхий хичээлийн хөтөлбөр төлөвлөлтийн гүйцэтгэл, сургуулийн болон ангийн төлөвлөгөөт ажил, сургуулийн дэд бүтэц хичээл хэрэглэгдэхүүний хангамж болон хяналт үнэлгээний олон чиглэлээр ангилж болох хэдий ч Арнштайн (1969) оролцооны , түвшинг *-үйлчлүүлэгч төвт* – иргэний хяналт, төлөөллийн дуу хоолой, түншлэл, *-бэлгэдлийн* – мэдээлэх, зөвлөлдөх, асуудал намжаах-санал авах,

-оролцооны бус – засах болон хууран мэхлэх гэж 8 түвшинд нэрлэсэн байна. Хөгжиж буй орнуудын олон нийт түүний боловсролын үйл ажиллагаан дахь оролцоог нарийвчлан тодорхойлох нь бэрхшээлтэй хэдий ч (Mikiko Nishimura, 2017) нэгд санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, хоёрт сургуулийн чанарыг сайжруулахтай холбоотой үйл ажиллагаа гэж хоёр ялган үзэж болох юм (Sumarsono, Imron, Wiyono, Agifin, 2016, p260).

Эхэнд дурьдсанчлан неолиберал бодлогын агентууд болон сургуульд суурилсан менежментийн үзэл санаа нь боловсролын үйлчилгээний хүртээмжийн нөлөө, үр ашгийг нэмэгдүүлэхэд олон нийтийн оролцоог чухалчилан үзэж байна. Эцэг эхийн дэмжлэг, сурлагын амжилтад үзүүлж буй нөлөөллийг Coleman-ий илтгэл анх танилцуулсан бол олон судлаачид тусгайлан судалж ирсэн байна. Taniguchi, Hirakawa (2016, p476) нар олон нийтийн оролцоо ба хүүхдийн суралцахуйн амжилт хооронд шууд эерэг хамааралтай, Bruns (2011) нар суралцагчийн гүйцэтгэлд сургуулийн бие даасан байдал, эцэг эхийн эгэх хариуцлага нөлөөлж байгааг, Murillo (2002,p387) сургуулийн сургалтын чанарыг сайжруулахад эцэг эхийн оролцоо чухал болохыг, Preedy, Herman, Yeh, Sumarsono (2016, p257) нар эцэг эхийн (олон нийт) оролцоо нь сурагчийн амжилт болон сургуульд хандах эцэг эхийн

сэтгэл ханамжтай эерэг хамааралтайг, Kimago, Machuma (2015,p8) нар сургуулийн үйл ажиллагаандах эцэг эхийн оролцоо, сурлагын чанар хооронд эерэг ач холбогдол бүхий хамаарал байгааг, Esther Ho (2017,p65) эцэг эхийн оролцоо, дэмжлэг хүүхдийн өөрийн үнэлгээ хооронд хамаарал байгааг тэмдэглэж байна. Энд онцлоход PISA тестийн 2000-2009 оны үр дүнд хийсэн судалгаагаар хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудад сургуулийн бие даасан байдал нь сурагчийн амжилтад сөрөг, харин өндөр хөгжилтэй болон хөгжингүй орнуудад эерэг хамааралтай байгааг Hanushek (2013) нар мэдээлсэн байна.

АРГА ЗҮЙ

2018-2019 оны хичээлийн жилд БЗД-ийн төрийн өмчийн 28 сургуулийн 1418 бүлэгт 51557 хүүхэд суралцаж байна. Түүврийн анхан шатны нэгжээр сургуулийг сонгож, хүүхдийн болон бүлгийн тоог харгалзан, хоёрдугаар шатанд системт түүврийн аргаар сургууль бүрээс пропорциональ аргаар бүлгийг хуваарилсан, гуравдугаар шатанд Олон нийтийн оролцоот сургуулийн өнөөгийн байдлыг сургуулийн үйл ажиллагаан дахь эцэг эхийн оролцооны хэлбэр, үйл ажиллагааны хүрээ, хандлагыг тодорхойлох асуумжийг төрийн өмчийн 10 сургуулийн 280 эцэг эхийн зөвлөлийн гишүүдээс санамсаргүй түүврийн аргаар авч

SPSS21 программ ашиглан боловсруулалт хийлээ.

ҮР ДҮН

Судалгаанд оролцогчдын статистик мэдээлэл 34,1% нь эрэгтэй, 65,9% нь эмэгтэй, нийт оролцогчдын 60,4% нь дээд боловсролтой, 28,8% бүрэн дунд, 10,8% нь бүрэн бус дунд болон тусгай боловсролтой байна. Судалгаанд оролцсон иргэдийн 53,6% нь 35 хүртэлх насны иргэд, нийт оролцогчдын 91,7% нь 2 түүнээс цөөн хүүхэдтэй байна.

Судалгаанд оролцсон 2 хүртэлх тооны хүүхэд нь ЕБС-д суралцдаг эцэг эхийн хүүхдүүдийн 66,1% нь бага ангид суралцаж байна.

Эцэг эхчүүдийн сургуулийн үйл ажиллагаанд оролцох хувь хүний давуу тал гэж нэрлэсэн үүрэг хариуцлагын гэсэн ойлголт бага ангид 56%, дунд ангид 47.7% харин ахлах ангид 30.8% болж буурсан бол оролцооны сул талаа ажлын цаг зав ачаалалтай холбон тайлбарласан бөгөөд энэ үзүүлэлт бага ангид 62.3%, дунд ангид 63.4% ахлах ангид 77.3% болж өссөн байна.

Сургуулийн үйл ажиллагаанд оролцож буй загварыг бага, дунд болон ахлах ангид 91.7%-95.2% нь ангийн багш болон ангийн эцэг эхийн зөвлөл гэж хариулсан бол оролцооны хэлбэр нь ангийн хурал гэж бага ангид 53.4%, дунд ангид 47,8%, ахлах ангид 29.6% нь онцолсон байна (хүснэгт1).

Хүснэгт 1. Сургуулийн үйл ажиллагаанд дахь оролцооны давуу ба сул тал

Бүлэг	Давуу тал		Сул тал		Оролцооны аргаар		Оролцооны хэлбэр	
	Уураг	Хувь	Уураг	Хувь	Уураг	Хувь	Уураг	Хувь
Бага анги	Уураг	56.0%	Цаг зав	62.3%	Ангийн багш болон ангийн эцэг эхийн оролцоо	92.5%	Ангийн хурал	53.4%
Дунд анги	Уураг	47.7%	Цаг зав	63.4%	Ангийн багш болон ангийн эцэг эхийн оролцоо	95.2%	Ангийн хурал	47.8%
Ахлах анги	Уураг	30.8%	Цаг зав	77.3%	Ангийн багш болон ангийн эцэг эхийн оролцоо	91.7%	Ангийн хурал	29.6%

Сургуулийн эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны хамрах хүрээг тодруулсан асуулгад нийт оролцогчдын 25,9% нь хүүхэд хамгаалал, 20,3% нь хандив тусламж, 14,7% нь сайн дурын үйл ажиллагаа гэж хариулсан бол 1.4% - 2.1% нь сургуулийн бодлого болон дүрмийг хэлэлцэх гэж хариулсан байна. Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны хүрээг хүүхэд нь суралцаж буй бүлгээр хүснэгтэд харуулснаас үзэхэд бага ангийн ангийн сурагчтай эцэг эхийн 29.8% нь Хүүхэд хамгаалал, дунд ангид 27.3% нь сайн дурын үйл ажиллагаанд эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа чиглэдэг гэсэн бол ахлах ангид 29.4% нь хандив тусламж авахад эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа чиглэж байна гэж үзсэн байна. (хүснэгт2).

Хүснэгт 2. Сургуулийн үйл ажиллагааны хамрах хүрээ

	Үйл ажиллагааны хүрээ	Хувь
Бага анги	Хүүхэд хамгаалал	29,8%
Дунд анги	Сайн дурын үйл ажиллагаа	27,3%
Ахлах анги	Хандив тусламж	29,4%

Асуулгын тохироц ба баталгаат чанар. Сургуулийн үйл ажиллагааны ил тод байдал нь эцэг эхийн оролцооны эрх мэдлийн

өөрийн үнэлгээтэй шууд, суралцаж буй хүүхдийн тоо нь сургуулийн үйл ажиллагаан дах эцэг эхийн эрх мэдэл болон ил тод байдлын үнэлгээтэй сөрөг хамааралтай байгаа нь корреляцийн шинжилгээнээс харагдаж байна (Хүснэгт3).

Хүснэгт 3. Корреляцийн шинжилгээ

		эс	хүүхдийн тоо	ил тод байдал	эрх мэдэл
ил тод байдал	Pearson Correlation	1	-.178 ^{**}	-.000	-.007
	Sig. (2-tailed)		.000	.999	.918
	N	245	245	245	245
хүүхдийн тоо	Pearson Correlation	-.178 ^{**}	1	-.174 ^{**}	-.228 ^{**}
	Sig. (2-tailed)	.000		.009	.001
	N	245	245	222	222
эрх мэдэл	Pearson Correlation	.000	-.174 ^{**}	1	-.739 ^{**}
	Sig. (2-tailed)	.999	.009		.000
	N	245	222	245	245
эс	Pearson Correlation	-.007	-.228 ^{**}	-.739 ^{**}	1
	Sig. (2-tailed)	.918	.001	.000	
	N	244	222	245	247

** . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Судалгааны асуулгын найдвартай байдлыг хэмжих кронбах альфа утга эцэг эхийн оролцооны эрх мэдэл ба сургуулийн үйл ажиллагааны ил тод байдлыг тодорхойлох асуулгад 0.847 гарсан нь найдвартай байдлыг илтгэж байна (Хүснэгт4).

Хүснэгт 4. Найдвартай байдал

Cronbach's Alpha	N of Items
.847	2

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Судалгааны үр дүнгээс харахад иргэдийн сургуулийн үйл ажиллагаан дахь оролцооны хэлбэр хангалтгүй (үйл ажиллагааны 48% нь эцэг эхийн хурал), боломж хязгаарлагдмал (64.1% нь эцэг эхийн цаг завьг харгалздаггүй, 13.4% нь үйл ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй), ганцхан чиглэлтэй (анги удирдсан багш

болон ангийн ЭЭЗ-өөр дамждаг 92%) тухайн сургууль дээр үйл ажиллагаа явуулдаг эцэг эхийн зөвлөлийн олон нийтийн статустай эсэхээс үл хамааран үйл ажиллагааны хүрээ нь хандив тусламж 20.3%-д төвлөрч байна. Мөн сургуулийн үйл ажиллагаан дахь эцэг эхийн оролцооны эрх мэдэл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд ялгаатай ($Z -2.040$, $p 0.041$), сургуулийн үйл ажиллагааны ил тод байдал, эцэг эхийн эрх мэдлийн үнэлгээнд сургууль дээрх эцэг оролцоо байгууллага бий болсон нь нөлөөлж байгааг судалгаа харууллаа.

ДҮГНЭЛТ

Олон нийтийн оролцоот сургуулийн үзэл санаа манай улсад хөгжиж байгаа хэдий ч өнөөдрийн байдлаар эцэг эхийн оролцоо нь хандив тусламж, сайн дурын үйл ажиллагаанд тулгуурласан материаллаг хэрэгцээг шийдвэрлэхэд чиглэж байна. Ялангуяа нийгэм, хүний хөгжлийн төв болсон сургуулийн үйл ажиллагаанд удирдлагын багийн ил тод нээлттэй үйл ажиллагаа дутагдаж, сургуулийн хөтөлбөр, сургалтын бодлогын хэлэлцүүлэгт эцэг эхийн оролцоо хязгаарлагдмал байна.

НОМ ЗҮЙ

1. Arnstein, S. (1969). A ladder of citizen participation. Journal of American Institute of Planners, 216-224.

2. Coleman, J. S. (1968). The Evaluation of Equality of Educational Opportunity. The John Hopkins University.
3. Geoffrey D, Borman., Maritza Dowling . (2010 May). Schools and Inequality: A Multilevel Analysis of Coleman's Equality of Educational Opportunity Data. Teachers College Record Vol 112 , 1201-1246.
4. Kimaro, A,R., Machumu,H,J. (2015). Impacts of Parental involvement in School Activeites on Academic Achievement of Primary School Children. International Journal of Education and Research 3(8).
5. Phillip. F.A Matshe Victor J Pitsoe. (2013). Promotion of Public Participation in School Environment. Mediterranean Journal of Social Sciences , 643-651 .
6. Preedy, M. (1993). Managing the Effective School. london : The Open Univercity .
7. Raden Bambang Sumarsono, Ali Imron, Bambang Budi Wiyono & Imron Arifin. (2016). Parents' Participation in Improving the Quality of Elementary School in the city of Malang, East Java, indonesia . International Education Studies, 256-262.
8. United Nations. (1981). Popular Participation as a Strategy for planning Comunity Level Action and National Development. New York: United Nations.
9. Вальдман, И. (2009, 4-р сарын 9). Сайт школы как инструмент для обеспечения в образовании. pp. 129-144.